



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/6/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: Anhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Содном

Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

Аудитор: А.Сувдаа

Утас: 70342495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэн өртгийн албан татвар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

1.Төрийн аудитын санал, дүгнэлт

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.АЛТАНШАГАЙ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчил нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Хувь хүмүүсээс авах авлага 20340.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй ч тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй
- Бараа материалын тайланг бэлтгэхдээ сар бүр тайлан гаргадаггүй, нярвын тайлангийн дүн санхүүгийн тодруулга тайлангийн дүнгээс 5329.6 мянган төгрөгийн орлого илүү, 8281.8 мянган төгрөгийн зарлага дутуу, 13611.4 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэл 14288.4 мянган төгрөгийн илүү буюу зөрүүтэй
- Байгууллагын эд хөрөнгийн эхний хагас жилийн хөрөнгийн тооллого зохион байгуулаагүй, жилийн эцсийн тооллого явуулах комисс томилсон ч Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан анхан шатны бүртгэлийн маягтын дагуу бэлтгээгүй, тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд зааврын

дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц, үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй ч хэрэгжүүлж ажиллаагүй, бараа материалын тооллогын баримт байхгүй

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	157,838,969.32	699,842,389.76
33	АВЛАГА	107,494,131.56	625,340,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	500,000.00	00.00
335	Бусад авлага	106,994,131.56	625,340,000.00
3351	Байгууллагаас авах авлага	81,654,131.56	605,000,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	25,340,000.00	20,340,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	50,344,837.76	74,502,389.76
351	Түүхий эд материал	16,262,000.00	16,262,000.00
35110	Тусгай зориулалттай материал	16,262,000.00	16,262,000.00
354	Хангамжийн материал	34,082,837.76	58,240,389.76
35410	Бичиг хэргийн материал	1,190,000.00	1,365,000.00
35420	Аж ахуйн материал	31,550,787.76	45,920,839.76
35440	Түлш, шатах тослох материал	1,260,000.00	2,080,000.00
35470	Бусад хангамжийн материал	82,050.00	8,874,550.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,518,624,612.88	5,413,059,072.90
39	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,518,624,612.88	5,413,059,072.90
392	Биет хөрөнгө	5,382,284,112.88	5,277,093,572.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,317,296,794.93	5,317,296,794.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	-258,131,926.22	-356,114,213.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	354,400,000.00	354,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-305,988,889.10	-321,388,889.18
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	293,688,910.58	332,515,080.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	-200,197,080.59	-214,377,855.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	252,042,254.28	253,613,988.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	-122,243,351.32	-139,856,734.58
39214	Бусад үндсэн хөрөнгө	59,327,770.00	59,327,770.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,910,369.68	-8,322,368.08
393	Биет бус хөрөнгө	136,340,500.00	135,965,500.00
39301	Програм хангамж	39,009,600.00	39,009,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-37,947,100.00	-38,322,100.00
39303	Бусад биет бус хөрөнгө	135,278,000.00	135,278,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,676,463,582.20	6,112,901,462.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	81,513,629.00	605,000,000.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	81,513,629.00	605,000,000.01
413	Өглөг	81,513,629.00	605,000,000.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	00.01
4136	Бусад өглөг	81,513,629.00	605,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	81,513,629.00	605,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,594,949,953.20	5,507,901,462.66
51	Засгийн газрын хувь оролцоо	5,594,949,953.20	5,507,901,462.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,104,006,679.64	1,104,006,679.64
51101	Өмч: - төрийн	135,278,000.00	135,278,000.00
51102	- хувийн	968,728,679.64	968,728,679.64
512	Хуримтлагдсан үр дүн	3,496,686,947.13	3,409,638,456.59
51210	Өмнөх үеийн үр дүн	3,496,686,947.13	3,496,686,947.13
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-87,048,490.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	994,256,326.43	994,256,326.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,676,463,582.20	6,112,901,462.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,252,473,561.00	3,047,685,566.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,559,450.00	59,469,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,559,450.00	59,469,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,559,450.00	18,269,800.00
120004	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,079,050.00	18,269,800.00
120004	5 Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,480,400.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,239,914,111.00	2,988,215,766.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	532,186,000.00	1,629,420,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,629,420,900.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	532,186,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	885,669,611.00	968,563,266.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	350,500,000.00	754,992,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,169,611.00	213,571,266.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	506,000,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,822,058,500.00	390,231,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,822,058,500.00	390,231,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,375,708,999.49	3,128,536,233.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,375,708,999.49	3,128,536,233.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,146,105,776.81	2,933,765,806.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	842,309,655.00	914,171,923.05
210101	Үндсэн цалин	464,313,461.00	535,159,654.05
210102	Нэмэгдэл	200,180,300.00	142,019,776.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,900,000.00	22,425,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	152,915,894.00	214,567,493.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,930,770.87	108,293,756.29
210201	Тэтгэврийн даатгал	68,321,899.27	75,096,646.85
210202	Тэтгэмжийн даатгал	7,656,922.29	8,108,577.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,125,537.83	6,486,861.22
210204	Ажилгүйдлийн даатгал	1,485,968.62	1,535,363.38
210205	Эрүүл мэндийн даатгал	16,340,442.86	17,066,307.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	222,429,400.00	222,156,828.00
210301	Гэрэл, цахилгаан	9,995,000.00	10,665,811.00
210302	Түлш, халаалт	201,634,400.00	199,982,091.00
210303	Цэвэр, бохир ус	10,800,000.00	11,508,926.00
2104	Хангамж, бараа материалын зардал	108,185,600.00	131,059,544.00
210401	Бичиг хэрэг	13,351,700.00	10,820,550.00
210402	Тээвэр, шатахуун	70,502,300.00	51,054,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,358,500.00	14,929,991.00
210404	Ном, хэвлэл	00.00	48,041,895.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,973,100.00	4,182,920.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	2,029,808.00
2105	Нормативт зардал	881,400.00	2,528,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	2,033,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	881,400.00	495,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	122,566,636.00	17,472,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,965.00	213,600.00
210602	Тавилга	265,000.00	00.00
210604	Урсгал засвар	122,250,671.00	17,258,750.00
2107	Томилолт, зочны зардал	110,930,800.00	38,081,200.00
210701	Гадаад албан томилолт	46,326,900.00	00.00
210702	Дотоод албан томилолт	64,603,900.00	20,581,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	17,499,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	820,841,895.00	858,784,303.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	813,812,310.00	849,028,710.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	456,000.00	3,348,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,558,510.00	3,054,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	419,575.00	418,225.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,474,500.00	2,325,500.00
210807	Газрын төлбөр	1,000,000.00	488,268.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	818,029,619.94	641,217,052.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	593,678,411.95	428,442,007.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,806,520.00	40,028,928.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	201,544,687.99	172,746,116.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	229,603,222.68	194,770,426.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	118,171,041.00	104,349,147.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	50,000,000.00	20,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,249,834.00	73,216,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,921,207.00	11,132,747.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	111,432,181.68	90,421,279.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,432,181.68	90,421,279.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-123,235,438.49	-80,850,667.34
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,802,777.00	6,197,823.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,513,920.00	6,197,823.20
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	12,288,857.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-15,802,777.00	-6,197,823.20
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-139,038,215.49	-87,048,490.54

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,299,127,207.41	3,087,999,195.00

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,079,050.00	18,269,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,079,050.00	18,269,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,079,050.00	18,269,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,079,050.00	18,269,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,289,048,157.41	3,069,729,395.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	532,186,000.00	1,629,420,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,629,420,900.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	532,186,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	934,803,657.41	1,050,076,895.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	49,134,046.41	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	350,500,000.00	754,992,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,169,611.00	213,571,266.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	506,000,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,822,058,500.00	390,231,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,822,058,500.00	390,231,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,178,640,277.39	3,049,500,795.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,178,640,277.39	3,049,500,795.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,948,920,982.01	2,249,730,368.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	835,220,294.00	913,671,923.00
210101	Үндсэн цалин	458,424,100.00	485,090,984.19
210102	Нэмэгдэл	200,180,300.00	202,629,005.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,900,000.00	18,912,878.17
210105	Гэрээт ажлын хөлс	151,715,894.00	207,039,055.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,296,497.00	108,153,253.73
210201	Тэтгэврийн даатгал	71,491,697.00	81,243,189.07
210202	Тэтгэмжийн даатгал	8,201,200.00	2,680,053.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,561,000.00	7,332,692.37
210204	Ажилгүйдлийн даатгал	1,640,200.00	401,517.14
210205	Эрүүл мэндийн даатгал	16,402,400.00	16,495,801.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	222,429,400.00	222,156,828.00
210301	Гэрэл, цахилгаан	9,995,000.00	10,665,811.00
210302	Түлш, халаалт	201,634,400.00	199,982,091.00
210303	Цэвэр, бохир ус	10,800,000.00	11,508,926.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,390,500.00	129,942,306.00
210401	Бичиг хэрэг	15,104,200.00	10,995,550.00
210402	Тээвэр, шатахуун	68,102,300.00	51,874,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,670,000.00	14,980,481.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	48,041,895.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,454,000.00	4,050,000.00
2105	Нормативт зардал	800,000.00	3,324,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	1,999,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	1,325,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	125,330,816.00	17,600,520.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,038,070.00	403,570.00
210602	Тавилга	1,765,000.00	00.00
210604	Урсгал засвар	122,527,746.00	17,196,950.00
2107	Томилолт, зочны зардал	110,430,800.00	38,081,200.00
210701	Гадаад албан томилолт	46,326,900.00	00.00

210702	Дотоод албан томилолт	64,103,900.00	20,581,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	17,499,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	826,452,995.00	256,832,523.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	819,423,410.00	247,076,930.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	456,000.00	3,348,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,558,510.00	3,054,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	419,575.00	418,225.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,474,500.00	2,325,500.00
210807	Газрын төлбөр	1,000,000.00	488,268.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	620,569,680.01	559,967,665.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	596,920,619.60	515,526,737.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,649,060.41	44,440,928.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	229,719,295.38	799,770,426.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	118,287,113.70	104,349,146.60
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	50,000,000.00	20,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,249,834.00	73,216,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,037,279.70	11,132,746.60
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	111,432,181.68	695,421,279.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,432,181.68	695,421,279.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	120,486,930.02	38,498,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	120,486,930.00	38,498,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	120,486,930.00	38,498,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	120,486,930.00	38,498,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	120,486,930.00	38,498,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-120,486,930.00	-38,498,400.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН						СТ-4А
						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
С01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,104,006,679.64	994,256,326.43	3,663,938,392.67	00.00	5,762,201,398.74
С02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-11,646,540.00	00.00	-11,646,540.00

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,104,006,679.64	994,256,326.43	3,652,291,852.67	00.00	5,750,554,858.74
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-139,708,515.49	00.00	-139,708,515.49
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,104,006,679.64	994,256,326.43	3,496,686,947.13	00.00	5,594,949,953.20
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,104,006,679.64	994,256,326.43	3,496,686,947.13	00.00	5,594,949,953.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,104,006,679.64	994,256,326.43	3,496,686,947.13	00.00	5,594,949,953.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-87,048,490.54	00.00	-87,048,490.54
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,104,006,679.64	994,256,326.43	3,409,638,456.59	00.00	5,507,901,462.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант он	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,043,292,000.00	1,966,770,080.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,043,292,000.00	1,966,770,080.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,941,075,600.00	1,862,420,933.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	923,626,900.00	897,278,884.95
210101	Үндсэн цалин	491,544,000.00	476,053,813.31
210102	Нэмэгдэл	205,940,000.00	202,629,005.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,800,000.00	18,912,878.17
210104	Урамшуулал	00.00	23,259,760.83
210105	Гэрээт ажлын хөлс	203,342,900.00	176,423,427.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,453,400.00	110,070,864.78
210201	Тэтгэврийн даатгал	115,453,400.00	83,160,800.12
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	2,680,053.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	7,332,692.37
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	401,517.14
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	16,495,801.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,685,500.00	222,156,828.00
210301	Гэрэл, цахилгаан	11,595,000.00	10,665,811.00
210302	Түлш, халаалт	201,634,400.00	199,982,091.00

210303	Цэвэр, бохир ус	10,456,100.00	11,508,926.00
2104	Хангамж, бараа материалын зардал	122,838,000.00	129,992,306.00
210401	Бичиг хэрэг	10,028,600.00	10,995,550.00
210402	Тээвэр, шатахуун	45,898,000.00	51,874,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,161,400.00	15,030,481.00
210404	Ном, хэвлэл	48,000,000.00	48,041,895.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,750,000.00	4,050,000.00
2105	Нормативт зардал	1,825,000.00	3,324,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	1,999,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,325,000.00	1,325,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,330,000.00	36,516,920.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,319,970.00
210604	Урсгал засвар	17,330,000.00	17,196,950.00
2107	Томилолт, зочны зардал	42,615,900.00	38,081,200.00
210702	Дотоод албан томилолт	22,615,900.00	20,581,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	20,000,000.00	17,499,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,778,000.00	11,894,973.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,260,500.00	2,139,380.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,348,000.00	3,348,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,055,000.00	3,054,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	418,300.00	418,225.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,326,000.00	2,325,500.00
210807	Газрын төлбөр	249,200.00	488,268.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	461922900.00	413104807.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	404,031,600.00	386,617,887.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	57,891,300.00	26,486,920.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102216400.00	104349146.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,216,400.00	104,349,146.60
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,000,000.00	20,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	73,216,400.00	73,216,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,000,000.00	11,132,746.60
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,043,292,000.00	2,037,922,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,645,060,400.00	1,629,420,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,645,060,400.00	1,629,420,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	390,231,600.00	390,231,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	390,231,600.00	390,231,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,000,000.00	18,269,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	18,269,800.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	70.00	70.00
620001	Удирдах ажилтан	07.00	07.00
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00
620004	Гэрээт ажилтан	27.00	27.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	70.00	70.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	36.00	36.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	31.00	31.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	03.00	03.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН		НТ-2 / төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	881,317,568.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	881,317,568.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	881,317,568.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,097,894.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,097,894.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,781,197.00
210201	Тэтгэврийн даатгал	1,781,197.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	799,423,410.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	799,423,410.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65015067.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,366,007.41
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,649,060.41
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	934803657.41
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	934,803,657.41
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	49,134,046.41
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	350,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,169,611.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	506,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг аймгийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Алтаншагай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн нийцэл, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 9-нөөс 2021 оны 02 дугаар сарын 25-ны Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор А.Сувдаа хариуцан гүйцэтгэв.

Булган аймгийн ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь төрийн аудитын газар-т 2021 оны 01 дүгээр сарын 22-нд-ны өдрийн 03/96 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагааны удирдлагыг оновчтой бодлого зохицуулалтаар хангаж, нутгийн захиргааны шийдвэр гаргах тогтолцоог дэмжихэд оршино” зорилгын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоол
- Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2020 оны А/106 дугаар
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 114 дүгээр тогтоол
- Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай Засгийн газрын 163 дугаар тогтоол,
- Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай Засгийн газрын 187 дугаар тогтоол
- Засгийн газрын 217, 218 дугаар тогтоол
- Хөдөлмөрийн дотоод журам

3.3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Аймгийн ЗДТГ санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагад яамны болон Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, харьяа орон нутаг дахь Санхүү хяналт аудитын газар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “62694.7 мянган төгрөг” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн нийт зардлын 1069957.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 21399.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Аймгийн ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 436437.9 мянган төгрөгөөр буюу 7.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	107494.1	625340.0	517845.9
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	50344.8	74502.4	24157.6
Үндсэн хөрөнгө	5518624.6	5412285.2	-106339.4
Нийт хөрөнгө	5676463.6	6112901.5	436437.9
Өр төлбөр	81513.6	605000.0	523486.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5594949.9	5507901.5	-87048.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5676463.6	6112901.5	436437.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 107494.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 625340.0 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 74502.4 мянган төгрөг болж 24157.6 мянган төгрөгөөр өссөн нь 11320.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирснээс шалтгаалжээ.

Тайлант хугацааны эцсийн үлдэгдлээр бичиг хэргийн материал 1365.0 мянган төгрөг буюу 1.15, аж ахуйн материал 45920.8 мянган төгрөг буюу 1.45, түлш, шатах тослох материал 2080.0 мянган төгрөг буюу 1.65, бусад хангамжийн материал 8874.6 мянган төгрөг буюу 108.2 дахин их үлдэгдэлтэй буюу материалын нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5412285.2 мянган төгрөг болж 106339.4 мянган төгрөгөөр буурсан нь 27980.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгаснаас шалтгаалжээ. Урсгал төсвийн худалдан авалтаар 38498.4 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 29880.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 27980.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 605000.0 мянган төгрөг болж 523486.4 мянган төгрөгөөр өссөн нь үлдэгдэл хөрөнгийг төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5507901.5 мянган төгрөг болж 87048.5 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлээс шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 207787.9 мянган төгрөгөөр буюу 6.3 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 247172.8 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, эд хогшил урсгал засварын зардал, томилолтын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга бичилт байхгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2942030.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2942030.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 808707.6 мянган төгрөгөөр бууруулж 2133322.4 мянган төгрөгөөр баталсан байна. Тодотголоор 90030.4 мянган төгрөгөөр бууруулж 2043292.0 мянган төгрөг болгож өөрчилжээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага, соёл урлаг хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2043292.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 2035292.0 мянган төгрөгийг улсын төсвөөс 8000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2019652.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 18269.8 мянган төгрөг, нийт 2037922.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1963048.4 мянган төгрөгийг зарцуулж 74873.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1963048.4 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 26467.1, ажил олгогчоос НДШ-д 8985.1, байр ашиглалттай холбоотой 1528.7, хангамжийн материал 145.9, эд хогшил урсгал

засварын зардал 813.1, томилолтын зардал 4534.7, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хөлс, төлбөр хураамж 122.9, бараа үйлчилгээний бусад зардал 36838.6, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 167.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээ 79604.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.6-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 49134.0 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 350500.0, , дээд шатны төсвийн захирагчаас 29169.6, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 506000.0 нийт 934803.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 15097.9, ажил олгогчоос НДШ-д 1781.2, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 799423.4, бараа үйлчилгээний бусад зардалд 65015.1 мянга, нийт 881317.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 53486.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 1003925.6, дээд шатны төсвийн захирагчаас 46151.3 нийт 1050076.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 16512.1, ажил олгогчоос НДШ-д 1684.9, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 254477.5, бараа үйлчилгээний бусад зардалд 156854.9 мянга, нийт 429529.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 620547.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбар, таван сая төгрөгөөс дээш дүнтэй 8 удаагийн 99646.0 мянган төгрөгийн орлого, 10 удаагийн 110953.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, 5 тушаал шийдвэр мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1760.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 34909.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 51731.3 мянган төгрөгийн 7 зөвлөмжийн хэрэгжилт 60.7 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1760.7	1	1760.7	0	0	0
Албан шаардлага	2	34909.3	2	34909.3	0	0	0
Зөвлөмж	7	51731.3	5	31391.3	2	20340.0	39.3
Нийт дүн	10	88401.3	8	68061.3	2	20340.0	23.0

Хэрэгжүүлээгүй 20340.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжид албан шаардлага өглөө.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 204648.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 120476.0 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 84172.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаанд залруулга хийгээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 120476.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 120476.0 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Хувь хүнээс авах насжилттай авлага 20340.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй ч тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" үүргийг хэрэгжүүлээгүй, өмнөх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны Б/12 тоот тушаалаар мэргэжилтэн А.Сарантуяа, Б/43 тоот тушаалаар хэвлэл, мэдээлэл олон нийттэй харилцах албаны дарга О.Ундрах, Б/57 тоот тушаалаар архивын тасгийн дарга Ш.Болдбаатар, Б/74 тоот тушаалаар Цэргийн штабын дарга Х.Золзаяа нарт 2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгосон нь /Холбогдох нотлох анхан шатны баримт байхгүй/ аймгийн ЗД-ын 2013 оны А/11 тоот захирамжаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх "Албан хаагчдад хүнд өвчний улмаас 1 сар түүнээс дээш хугацаагаар эмчлүүлэх тохиолдолд хугацааг харгалзан 0,5-2 сар хүртэлх сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг жилд 1 удаа Тамгын газрын албан хаагчид болон харьяалал бүхий өндөр настнуудад олгох", аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны А/18 тоот тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам" -ын 7 дугаар зүйлийн 7.2.5 дахь "Албан хаагч хүнд өвчний улмаас 1 сар ба түүнээс дээш хугацаагаар эмчлүүлэх болсон тохиолдолд эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн 1-2 сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний тусламжийг жилд нэг удаа олгоно" гэж заасныг зөрчсөн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

3. Цалингийн өглөг дансаар дамжуулалгүй нийт 17959.1 мянган төгрөгийн цалинг шууд зардлаар бүртгэж тайлагнасан, 1760.6 мянган төгрөгийн актын төлбөрийг бусад зардлын тооцооны авлага дансаар дамжуулсан, 65643.2 мянган төгрөгийн урьдчилгааг хувь хүмүүсээс авах авлага дансаар дамжуулалгүй цалингийн өглөг данс руу бичилт хийсэн нь

НББ-ийн холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор бүртгэж хөтлөөгүй, тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Байгууллагын эд хөрөнгийн эхний хагас жилийн хөрөнгийн тооллого зохион байгуулаагүй, жилийн эцсийн тооллого явуулах комисс томилсон ч Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан анхан шатны бүртгэлийн маягтын дагуу бэлтгээгүй, тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй ч хэрэгжүүлж ажиллаагүй, бараа материалын тооллогын барим байхгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих", НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна" гэж заасны дагуу хариуцлагагүй хандсан, тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

5. Тус байгууллагын санхүүгийн тайланд нярвын тайлан санхүүгийн тодруулга тайлан зөрүүтэй, өглөгөөр тусгаагүй өмнөх оны томилолт болон үйл ажиллагааны үлдэгдэлд санхүүжилт олгосон, дансны бичилт буруу хийсэн, тооллогын үр дүнг тооцоогүй, агуулахад байгаа бараа материалыг тооллогод харуулаагүй, аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй зэрэг нь НББ-ийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4¹.1-д "Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын хариуцлага тооцох албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 84172.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 9 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт болон дотоод хяналтын талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Бараа материалын тайланг бэлтгэхдээ сар бүр тайлан гаргадаггүй, нярвын тайлангийн дүн санхүүгийн тодруулга тайлангийн дүнгээс 5329.6 мянган төгрөгийн орлого

илүү, 8281.8 мянган төгрөгийн зарлага дутуу, 13611.4 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэл 17770.4 мянган төгрөгийн илүү нь НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн.

1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, үүрэгт ажилд хариуцлагагүй хандсанаас сахилгын шийтгэл хүлээх

1.3. Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 6.1, 13.1, 13.5-13.7 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2.Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны А/05 тоот тушаалаар Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан албан хаагчид 280.0 мянган төгрөгийн хүндэтгэл үзүүлсэн нь Хөдөлмөрийн дотоод журмын 6.1.2 дахь заалтыг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл: Үргүй зардал гарах, журам зөрчигдөх

2.3. Өгсөн зөвлөмж: Хөдөлмөрийн дотоод журмын 6.1.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3.Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: 2019 оны 11, 12 сард албан томилолтоор ажилласан 10 ажилтанд олгох томилолтын дутуу 1085.2 мянган төгрөгийг 2019 оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байж олгосон нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.2 дахь "тасралтгүй байх", 5.1.3 дахь "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-д "бүх өр төлбөр" гэж заасныг хэрэгжүүлээгүй

3.2. Эрсдэл: Тайлан буруу илэрхийлэгдэх, дотоод хяналт сулрах

3.3. Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 6.1, 20 дахь заалтын дагуу тооцооллыг тухай бүр хийх, төсвийг зохистой удирдах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Аймгийн 2019 оны Шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой үлдэгдэл 2180.5 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэж тооцоо нийлээгүй ч барагдуулсан байна.

4.2. Эрсдэл: Тайлан буруу илэрхийлэгдэх, дотоод хяналт сулрах, үргүй зардал гарах

4.3. Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 20 дахь заалтын дагуу тооцооллыг тухай бүр хийх, төсвийг зохистой удирдах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

5.Зардлын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөр олж бэлтгэсэн материаллаг хөрөнгийг шууд зарлагадан орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн "6.1.Аж ахуйн

нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө" гэж заасныг зөрчсөн байна.

5.2. Эрсдэл: Үргүй зардал гарах, хөрөнгө шамшигдуулах

5.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Маягт заавар батлах" журам, НБББББ-т тусгасны дагуу холбогдох дансанд орлогоор хүлээн зөвшөөрч холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэж өгөх

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

6. Шилэн данстай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт: Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбар, таван сая төгрөгөөс дээш дүнтэй 8 удаагийн 99646.0 мянган төгрөгийн орлого, 10 удаагийн 110953.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, 5 тушаал шийдвэр мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.6, 6.4.5 Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 2.2.1.6, 2.2.1.13 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

6.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, мэдээлэл буруу хүргэх

6.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.1.6, 6.4.5, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 2.2.1.6, 2.2.1.13 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

7. Худалдан авалттай холбоотой асуудал

7.1. Илрүүлэлт: Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр 132451.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй нь эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

7.2. Эрсдэл: Орлогыг нуун дарагдуулах, тайлагнахгүй байх

7.3. Өгсөн зөвлөмж: НӨАТ тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших

7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

8. Зардлын данстай холбоотой асуудал

8.1. Илрүүлэлт: Цалингийн зардлаас хоёр албан хаагчдад 2209.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь Засгийн газрын 5 дугаар тогтоолыг үндэслэх, Сангийн сайдын 2014 оны 55, 2015 оны 7 дугаар журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

8.2. Эрсдэл: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа доголдох, дотоод хяналт сулрах

8.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 5 дугаар тогтоолыг үндэслэх, Сангийн сайдын 2014 оны 55, 2015 оны 7 дугаар журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

8.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

9. Дотоод хяналттай холбоотой асуудал

9.1. Илрүүлэлт: Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолоор тус аймгийн ЗДТГ-ын бүтэц орон тоог 37 хүртэл, 5 хэлтэс 1 штабтай байхаар тогтоосон ч ЗДТГ-ын даргын 2017 оны Б/12 тоот тушаалаар 6 хэлтэс, 1 штаб, 1 тасаг, 2 албатай ТЗ-ны 44, ТҮ-25 нийт 69 ажилтантай байхаар тогтоож 2020 оны гүйцэтгэлээр нийт 71 орон тоотой ажилласнаас баталсан орон тоогоор угтах үйлчилгээний ажилтан дутуу, жолооч илүү ажилласан байна.

9.2. Эрсдэл: ЗГ-ын тогтоол зөрчигдөх, үргүй зардал гарах

9.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын дагуу бүтэц орон тоог шинэчлэн батлах

9.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР

Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

А.СУВДАА

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			БУА-2021/6/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган аймгийн ЗДТГ		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хувь хүнээс авах авлага 20340.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй ч тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй	20340.0	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан
2	Бараа материалын тайланг бэлтгэхдээ сар бүр тайлан гаргадаггүй, нярвын тайлангийн дүн санхүүгийн тодруулга тайлангийн дүнгээс 5329.6 мянган төгрөгийн орлого илүү, 8281.8 мянган төгрөгийн зарлага дутуу, 13611.4 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэл 14288.4 мянган төгрөгийн илүү буюу зөрүүтэй	14288.4	НББ-ийн тухай хуулийн 6.1, 13.1, 13.5-13.7 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэх зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан
3	Хөдөлмөрийн дотоод журмын 6.1.2 дахь заалтыг зөрчин хүндэтгэл үзүүлсэн	130.0	Хөдөлмөрийн дотоод журмын 6.1.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэх зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан
4	Нэр бүхий 4 албан хаагчдад мөнгөн тэтгэмж олгосон, зөвлөмжийг биелүүлж ажиллаагүй	5913.9	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан
5	2019 оны 11, 12 сард албан томилолтоор ажилласан 10 ажилтанд олгох томилолтын дутуу 1085.2 мянган төгрөгийг 2019 оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байж олгосон	2165.2	НББ-ийн тухай хуулийн 6.1, 20 дахь заалтын дагуу тооцооллыг тухай бүр хийх, төсвийг зохистой удирдах зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан
6	Аймгийн 2019 оны Шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой үлдэгдэл 2180.5 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэж тооцоо нийлээгүй ч барагдуулсан	2180.5	НББ-ийн тухай хуулийн 20 дахь заалтын дагуу тооцооллыг тухай бүр хийх, төсвийг зохистой удирдах зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан
7	Засаг даргын нөөц хөрөнгөөр олж бэлтгэсэн материаллаг хөрөнгийг шууд зарлагадан орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байна.	63199.7	Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Маягт заавар батлах" журам, НБББББ-т тусгасны дагуу холбогдох дансанд орлогоор хүлээн зөвшөөрч холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэж өгөх зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан
8	Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбар, таван сая төгрөгөөс дээш дүнтэй 8 удаагийн 99646.0 мянган төгрөгийн орлого, 10 удаагийн		Шилэн дансны тухай хуулийн 6.1.6, 6.4.5, Шилэн дансны цахим хуудсанд тавих	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан

Булган аймгийн ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	110953.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, 5 тушаал шийдвэр мэдээлээгүй		мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 2.2.1.6, 2.2.1.13 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх		
9	Цалингийн өглөг дансаар дамжуулалгүй нийт 17959.1 мянган төгрөгийн цалинг шууд зардлаар бүртгэж тайлагнасан, 1760.6 мянган төгрөгийн актын төлбөрийг бусад зардлын тооцооны авлага дансаар дамжуулсан, 65643.2 мянган төгрөгийн урьдчилгааг хувь хүмүүсээс авах авлага дансаар дамжуулалгүй цалингийн өглөг данс руу бичилт хийсэн	19719.7	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан
10	Цалингийн зардлаас хоёр албан хаагчдад 2209.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон	2209.0	Засгийн газрын 5 дугаар тогтоолыг үндэслэх, Сангийн сайдын 2014 оны 55, 2015 оны 7 дугаар журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан
11	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр 132451.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй нь эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.		НӨАТ тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан
12	Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолоор тус аймгийн ЗДТГ-ын бүтэц орон тоог 41 хүртэл, 5 хэлтэс 1 штабтай байхаар тогтоосон ч ЗДТГ-ын даргын 2017 оны Б/12 тоот тушаалаар 6 хэлтэс, 1 штаб, 1 тасаг, 2 албатай ТЗ-ны 44, ТҮ-25 байхаар тогтоож 2020 оны гүйцэтгэлээр нийт 71 орон тоотой ажилласан байна.		Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын дагуу бүтэц орон тоог шинэчлэн батлах зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан
13	Байгууллагын эд хөрөнгийн эхний хагас жилийн хөрөнгийн тооллого зохион байгуулаагүй, жилийн эцсийн тооллого явуулах комисс томилсон ч Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан анхан шатны бүртгэлийн маягтын дагуу бэлтгээгүй, тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй ч хэрэгжүүлж ажиллаагүй, бараа материалын тооллогын барим байхгүй	74502.4	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан
14	Ажил үүргийн хариуцлага алдсан		Сахилгын хариуцлага тооцох албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Алтаншагай, Д.Баясгалан
ДҮН		204648.8			